

Батлав:
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

D. Batmang

Д.БАТСҮХ

УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙР СУУЦНЫ
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГЭРЭЭ

2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох хууль тогтоомж, дагаж мөрдөх журам, стандартад хяналт тавих түүний хэрэгжилтийг дээшлүүлэх зорилгоор нэг талаас Нийслэлийн Аялал жуулчлалын газар, нөгөө талаасдүүрэг, ...дугаар хорооны-д байршилтайнэртэй /зочид буудал, дэн буудал, гэст хаус, амралтын газар, жуулчны бааз, гэр буудал/-ын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн.....овогтой.....,ХХК-ийг төлөөлж захирал менежер овогтой..... нар дор дурдсан нөхцөл, хугацаагаар гэрээ байгуулав.

1.2. Гэрээ нь нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна

ХОЁР.ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу эрхэлж шинэ үйлчилгээ технологийг нэвтрүүлж байгаа байгууллагуудыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, олон улсын болон дотоодын үзэсгэлэн, мэргэжлийн сургалт, арга хэмжээнүүдэд оролцуулах, шилдэг байгууллага аж ахуйн нэгжээр шагналд тодорхойлох болон бусад төрлийн дэмжлэг үзүүлнэ.

2.2. Үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах зохих журмын дагуу арга хэмжээ авах, хүлээх үүргээ биелүүлэхийг шаардах зэргээр гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.

2.3. Үйлчилгээний байгууллага нь хууль тогтоомж, журам дүрэм, стандарт үйлчилгээний харилцааны доголдол гаргаж үйлчлүүлэгчдийг хохироосон тохиолдолд тухайн байгууллагад эхний ээлжид сануулах арга хэмжээ авч давтан зөрчил гаргавал гэрээг цуцлан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг хураах арга хэмжээ авна.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ИРГЭН,
АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Үйлчилгээ эрхлэгч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдөх журам, дүрэм төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлж ажиллана.

3.2 Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч нь ажлын байрны аюулгүй ажиллагааг тогтмол хангаж ажиллана.

3.3 Үйлчилгээ эрхлэгчид нь нийгэм эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, иргэдийн эрх ашигт нийцсэн үйлчилгээг бий болгож нийслэл хотын өнгө үзэмж тохижилтод хувь нэмэр оруулж, орон нутгийн төр захиргааны байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийг хамарсан ажилд идэвх санаачлагатай оролцож нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Үйлчилгээ эрхлэгч нь иргэдэд үзүүлж буй үйлчилгээний үнэ, зурагт танилцуулга, нэмэлт үйлчилгээний төрлүүд, чухал шаардлагатай мэдээлэл, утасны жагсаалт, яаралтай тусламжийн дугаар, байгууллагын дотоод журам зэргийг ил тод байрлуулна.

3.5 Үйл ажиллагааны талаар бүх шатны төрийн захиргааны болон эрх бүхий албан тушаалтны өгөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж стандартын үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгаж, үйлчлүүлэгчдээс ирсэн санал гомдлыг хүлээн авч шуурхай барагдуулж санаачлагатай ажиллана.

3.6 Үйлчлүүлэгчдийн хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааг явуулж үйлчилгээний чанарыг тодорхойлох, нийт үйлчлүүлсэн зочдын тоог ор хоногоор гаргаж байгууллагын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн тайлан гаргаж улирал болгоны сүүлийн долоо хоногт Нийслэлийн аялал жуулчлалын газарт ирүүлж, зөвлөгөө мэдээлэл авч улс нийслэлийн чанартай тэмдэглэлт өдрүүдэд хамрагдан шагнал урамшуулалд байгууллага ажилтнаа тодорхойлно.

3.7 Жуулчид, үйлчилүүлэгчийн аюулгүй байдлыг бүх түвшинд хангаж ажиллана. Үүнд орон байрны, хоол хүнсний, гэмт халдлагын, унаа тээврийн болон тухайн байгууллагын ойр орчимын газрын аюулгүй байдлыг хамааруулж ойлгоно.

3.8 Нийслэл хотын агаар болон орчины бохирдолыг бууруулах ажилд хувь нэмэр оруулж ажиллах, бохирдол үүсгэж байгаа хэрэглээнээсээ татгалзах, бууруулах талаар ямар нэгэн ажил зохион байгуулж санаачлага гаргасан байна.

ДӨРӨВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

4.1 Энэ гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаан, санал зөрөлдөөнийг харилцан зөвшилцлийн журмаар шийдвэрлэнэ. Маргааныг хэлэлцэн шийдвэрлэх боломжгүй бол хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

ТАВ. БУСАД НӨХЦӨЛҮҮД

5.1 Энэ гэрээнд оруулах өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж, талуудын төлөөлөгч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

5.2 Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Захиргааны хариуцлагын тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, НИТХ-ийн 2011 оны 120 дугаар тогтоол, болон бусад холбогдох хууль журам, дүрэм зөрчвөл энэхүү гэрээг цуцлан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хураан авна.

5.3 Гэрээний сунгалтыг үйлчилгээ эрхлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу холбогдох материал, стандартын үнэлгээг үндэслэн хийнэ. Хугацаа дуусахаас 15 хоногийн өмнө сунгалтын хүсэлт гаргана. Сунгалт хийлгээгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээ цуцлагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН	
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН	ХХК-ийг төлөөлж
.....овогтой.....	иргэн.....овогтой.....
Хаяг: ЧД, 4-р хороо, Нийслэлийн Засаг Захиргааны 4-р байр Утас: 70148687 Факс: 70128687 Цахим хаяг: tuulsaindorj@gmail.com	Хаяг: Утас: Факс: Цахим хаяг:

НХМаягт-1 Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын
2002 оны 171/111 тушаалын хавсралт 2002 оны 6-р сарын 18-ний

НЭХЭМЖЛЭХ №

Төлөгч:

Байгууллагын нэр

Хаяг

Гэрээний №

Нэхэмжлэх огноо

Нэхэмжлэх огноо

Төлбөр хийх хугацаа

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Гэрчилгээний үнэ	1	5000	5000
			Дүн НӨАТ	
			Нийт дүн	5000

Мөнгөний дүн: 5000 /Таван мянга/ төгрөг болно.

Дарга:

/ Д.Батсүх /

Нягтлан бодогч

/Г.Цэрэннадмид/

Тамга

Дарга:

/ Д.Батсүх /

Нягтлан бодогч

/Г.Цэрэннадмид/